



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 15 өдөр

Дугаар А/429

Мөрөн сум

Төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.6, 65 дугаар зүйлийн 65.1.4, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн ээлжит XX хуралдааны 07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн орон нутгийн хөгжлийн сан дахь “Зураг төсвийн сан”-аас санхүүжүүлэх шинээр барих, засварлах, шинэчлэх барилга байгууламжийн ажлын зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаарыг 1 дүгээр, “ажлын гүйцэтгэл”-ийн төсвөөс санхүүжүүлэх зөвлөх үйлчилгээний төлбөрийн төсөвт өртгийн дээд хязгаарыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Төсөл арга хэмжээний зураг, төсвийг боловсруулах зөвлөх үйлчилгээ нийлүүлэх гүйцэтгэгч сонгож гэрээ байгуулах, хэрэгжилтийг хангах үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газар (Б.Должинсорогдог), сумын Засаг дарга, агентлаг байгууллагын удирдлагуудад тус тус үүрэг болгосугай.

3. Төсөл арга хэмжээнүүдийн зураг төсвийн үнийг хавсралтад заагдсан эх үүсвэрээс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Базар), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Оюунтуяа) нарт тус тус даалгасугай.

4. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Хөвсгөл аймагт хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний зураг, төслийн даалгавар, техникийн нөхцөл, техникийн тодорхойлолт зэрэг холбогдох баримт бичгийг бэлтгэн Орон нутгийн өмчийн газарт хүргүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Оюунтуяа), сумын Засаг дарга, агентлаг байгууллагын удирдлагуудад тус тус үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т даалгасугай.

6. Энэ захирамж гарсантай холбогдуулан “Төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” Аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн А/126 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтын “Цэцэрлэг сумын халаалтын зуухны янданг солих ажлын зураг төсөл боловсруулах...”, 2021 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн А/213 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтын “Мөрөн сумын 5 дугаар цэцэрлэгийн 150 хүүхдийн цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын ажил...” гэсэн хэсгийг тус тус хүчингүй болгосугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ

Захирамж-2023

6712011051

Аймгийн Засаг даргын 2023 оны 09
дүгээр сарын 15-ны өдрийн
А/479 дугаар захирамжийн 1 дүгээр
хавсралт

АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН ДАХЬ “ЗУРАГ ТӨСВИЙН САН”-ААС
САНХҮҮЖҮҮЛЭХ ШИНЭЭР БАРИХ, ЗАСВАРЛАХ, ШИНЭЧЛЭХ, БАРИЛГА
БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ТӨЛБӨРИЙН ТӨСӨВТ ӨРТГИЙН ДЭЭД ХЯЗГААР

№	Арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	тайлбар
1	1.“Сод-Эрдэм” сургуулийн баруун талын хатуу хучилттай авто замын төгсгөлөөс: 1.1 тойрог үүсгэн MCS-ийн агуулахын урд талын 3 замын уулзвар хүртэлх авто зам 1.2 Мөрөн сумын төвлөрсөн хог хаягдлын цэгийн хяналтын пүү хүрэх авто зам 2. Тухайн тойрог замын хэвтээ тэнхлэгийн дагуух холбоос замуудын ажлын зураг төсөл боловсруулах	55,000,000	Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна
2	5-р цэцэрлэгийн өргөтгөлийн барилга /150 хүүхэд/-ын ажлын зураг төсөл боловсруулах	25,000,000	Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна
3	Цэцэрлэг сумын халаалтын зуухны янданг солих ажлын зураг төсөл боловсруулах	7,000,000	Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна
4	Мөрөн сумын хог хаягдлын төвлөрсөн цэгийн талбайг хумьж тархалтыг бууруулах, нэг цэгээр нэвтрэх гарц гаргаж зогон татах, хаягжуулах, камержуулах ажлын зураг төсөл боловсруулах	5,000,000	Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна
5	Нэгдсэн эмнэлгийн дээврийн засварын ажлын зураг төсөл боловсруулах	3,000,000	Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан

			шаардлагыг хангасан байна
6	Төв музейн үзвэрийн танхим, хүүхдийн уншлагын танхимын халаалтын шинэчлэлт засварын ажлын зураг төсөл боловсруулах	2,000,000	Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна
7	Аймгийн баяр наадмын талбайн хиймэл ногоон зүлэг, гүйлтийн замын засвар шинэчлэлтийн ажлын зураг төсөл боловсруулах	1,000,000	Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна
	Нийт дүн	98,000,000	

Аймгийн Засаг даргын 2023 оны 09
дүгээр сарын 15-ны өдрийн
А/479 дугаар захирамжийн 2 дугаар
хавсралт

УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ШИНЭЭР БАРИХ,
ЗАСВАРЛАХ, ШИНЭЧЛЭХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН “АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ”-
ИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛЭХ ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ЗӨВЛӨХ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨСӨВТ ӨРТГИЙН ДЭЭД ХЯЗГААР

№	Арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	тайлбар
1	Мөрөн сумын багуудад таксины зогсоол байгуулах ажлын зураг төсөл боловсруулах	9,260,000	Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна
	Нийт дүн	9,260,000	